



Иргэний нисэхийн
ерөнхий газар

Систем даяарх МЭДЭЭЛМИЙН МЕНЕЖМЕНТ

SWIM/1

ХУРЛЫН ТАЙЛАН

БҮЛЭГ НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Танилцуулга

Систем даяарх мэдээллийн менежмент(SWIM)-ийн ажлын багийн анхдугаар хурал 2019.03.26-ны 14:00 цагаас 16:30 цагийн хооронд ИНЕГ-ын хурлын танхимд АНБЗГ, НУТА, НМҮА, МТИСХА, ОХЗЛ, НЦУТ байгууллагуудын нийт 23 хүний бүрэлдэхүүнтэйгээр(Хавсралт 1-т) зохион байгуулагдлаа.

БҮЛЭГ ХОЁР. ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Хурлын танилцуулга

Хурлыг SWIM-ийн ажлын багийн ахлагч Д.Үлэмж удирдаж, хурлын хөтөлбөрийг (Хавсралт-2-т) танилцуулсан. Хурлын хөтөлбөрт SWIM-ийн ажлын багаас танилцуулагдах илтгэлүүд, SWIM-тэй холбоотой дэд ажлын хэсгүүд болон алба салбаруудаас хийгдэж байгаа ажлууд, өнөөгийн байдал, хэрэгжилтийн талаарх илтгэлүүд багтана. Мөн "Survey on implementation of SWIM services" судалгааны асуулгыг хамтарч бөглөх талаар танилцуулсан.

2. Хурлын нээлт

Хурлыг ИНЕГ-ын АНБЗГ-ын дарга Ё.Эрдэнэбат нээж, үг хэлэв. Тэрээр хурлын нээлтийн үеэр Монголын агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангах ажлын хэсэг (MANPING)-ын зорилго, ерөнхий ойлголтыг танилцуулж, ажлын хэсгүүд, ажлын багууд хариуцсан хурлуудаа өндөр хэмжээнд зохион байгуулах, түүнд идэвхтэй оролцохыг уриалав. Ажлын багууд хурал бүрийн дараа хурлын явцад гарсан асуудлуудаа MANPING-ын журмын дагуу тайлагнаж, MANPING-ын удирдах зөвлөлд хандаж шийдвэрлүүлж байх талаар онцолсон.

3. Хурлын илтгэлүүд

Хуралд дараах сэдвээр илтгэлүүд тавигдав. Илтгэлийн дэлгэрэнгүйг Хавсралт-3-т оруулсан.

№	Илтгэлийн сэдэв	Илтгэгч
1.	SWIM-ийн талаарх ерөнхий ойлголт	НМҮА-ны дэд дарга Д.Үлэмж
2.	SWIM-ийн талаар Ази номхон далайн бүсээс хийгдэж буй ажил, МУ-ын өнөөгийн байдлын талаар	НМҮА-ны өгөгдлийн инженер У.Алтанцэцэг
SWIM-ийн бүтээгдэхүүний талаарх танилцуулга		
3.	AIXM-ийн ерөнхий ойлголт, одоогийн байдал	НМҮА-ны НМЭ-ийн мэргэжилтэн Б.Болдбаяр
4.	FIXM-ийн талаарх ерөнхий ойлголт, одоогийн байдал	НУТА-ны менежер Г.Батбаяр
5.	WXXM-ийн талаарх ерөнхий ойлголт, одоогийн байдал	НЦУТ-ийн ЕТИнженер Г.Сүхбаатар
6.	CRV-ын талаарх ерөнхий ойлголт, одоогийн байдал	АНБЗГ-ын мэргэжилтэн Н.Эрдэнэсүх
7.	SWIM-ийн хамтын ажиллагаа	МТИСХА-ны мэргэжилтэн Б.Нямбаяр
Судалгаа		
8.	Survey on implementation of SWIM services	НМҮА-ны дэд дарга Д.Үлэмж

4. Хурлаар хэлэлцсэн асуудлууд

- 4.1. SWIM-ийг хэрэгжүүлэх ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүдийг байгуулах талаар дараах саналууд гарсан. Үүнд:
- 4.1.1. SWIM-ийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулахдаа SWIM-ийн төлөвлөгөө гаргасан ажлын хэсэгт суурилж ажлын багийг бүрдүүлэх тухай санал.
- 4.1.2. SWIM-ийг хэрэгжүүлэх ажлын хэсэг дотор ANS-ийн хэмжээнд идэвхтэй оролцож байгаа, ажлын хэсэгт орох сонирхолтой хүмүүсээс санал аваад, тэр хүмүүс дундаас мэргэжлийн хүмүүсийг авч ажлын хэсэг байгуулах санал.
- 4.1.3. CRV, FIXM-ын дэд ажлын хэсэг байгуулах шаардлагагүй. Эдгээр нь MANPING-ын ажлын баг, ажлын хэсэг болон НУТА-ны үйл ажиллагаагаар шийдэгдэх боломжтой гэж үзсэн талаарх санал.
- 4.1.4. SWIM-ийг хэрэгжүүлэх үндсэн ажлын хэсгээ байгуулаад, тэр ажлын хэсэг нь дэд ажлын хэсгүүдийг байгуулах шаардлагатай эсэхийг тодорхойлж гаргах саналтай байна.
- 4.2. Нислэгийн цаг уурын төвийн бүтэц зохион байгуулалт нь өөр яам, газарт харьяалагддаг тул SWIM-ийг хэрэгжүүлэхэд оролцох хүмүүсийн эрхзүйн зохицуулалт яаж хийгдэх вэ? Олон улсын хуралд хэрхэн оролцох вэ? Хөрөнгө санхүүгийн асуудлыг хэрхэн шийдэх тухай оролцогчдоос асуулт асуусан. Хамтын гэрээнд өөрчлөлт оруулж ирвэл MANPING-ээс санал оруулж, шийдвэрлүүлэх боломжтой талаар хэлэлцэв.
- 4.3. SWIM Task Force 3-р хуралд МУ-аас оролцох төлөвлөгөөний талаар
- 4.3.1. Ажлын багийн зүгээс SWIM Task Force хуралд оролцохдоо МУ-ын SWIM-ийг хэрэгжүүлэх 2019-2030 оны төлөвлөгөөний талаар, Ажлын хэсгүүд байгуулагдах талаар танилцуулга хийх.
- 4.4. SWIM-ийн монгол нэрийн орчуулгын талаар ярилцав. Одоогоор “Систем даяарх мэдээллийн менежмент” нэрийг ашиглаж байх. Нэрийн асуудлыг дараа хэлэлцүүлж тогтохоор боллоо.
- 4.5. Survey on implementation of SWIM Services судалгааг хуралд хамааралтай ажлын багууд бөглөөд, SWIM-ийн ажлын багт ирүүлэх.

5. Хурлаас гарсан шийдвэр

Шийдвэр 1.

Шийдвэрийн төсөл SWIM-1: SWIM-ийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах	
<p>Юу: SWIM-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг яаралтай байгуулах нь зүйтэй. Ажлын хэсэг байгуулахдаа SWIM-ийн төлөвлөгөөнд тусгагдсан CRV, FIXM-ийн дэд ажлын хэсгийг байгуулах шаардлагагүй. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аль болох тухайн ажлын хэсэгт орж ажиллах саналтай хүмүүсээр бүрдүүлэх</p>	<p>Хүсэж буй үр дүнгийн нөлөөлөл:</p> <p><input type="checkbox"/> Дэлхийн улс орнуудын хэмжээнд</p> <p><input type="checkbox"/> APAC бүсийн хэмжээнд</p> <p><input type="checkbox"/> Эдийн засаг</p> <p><input type="checkbox"/> Байгаль орчин</p> <p><input checked="" type="checkbox"/> Үйл ажиллагаа/Техникийн түвшинд</p>
<p>Яагаад: SWIM-ийг хэрэгжүүлэх ажлыг хэсэг байгуулагдаж, төлөвлөгөөний дагуу ажлын дэд хэсэг байгуулах эсэхийг тодорхойлж, судалгааны ажлыг эхлүүлэх.</p>	<p>Шийдвэр гаргагч/Follow up: MANPING</p>
<p>Хэзээ: 2019 оны 4-5-р сард</p>	<p>Төлөв: Шийдвэр гаргуулах</p>
<p>Хэн: <input checked="" type="checkbox"/> SWIM-ийн ажлын баг <input type="checkbox"/> CNS/SG дэд ажлын хэсэг <input type="checkbox"/> MANPING <input type="checkbox"/> ИНЕГ</p>	

Шийдвэр 2.

Шийдвэрийн төсөл SWIM-1: SWIM-ийн монгол нэрийн хувилбар гаргах	
Юу: Ажлын багаас SWIM-ийн монгол нэрийн оновчтой хувилбарыг гаргаж, саналыг хүргүүлэх	Хүсэж буй үр дүнгийн нөлөөлөл: <input type="checkbox"/> Дэлхийн улс орнуудын хэмжээнд <input type="checkbox"/> APAC бүсийн хэмжээнд <input type="checkbox"/> Эдийн засаг <input type="checkbox"/> Байгаль орчин <input checked="" type="checkbox"/> Үйл ажиллагаа/Техникийн түвшинд
Яагаад: “Систем даяарх мэдээллийн менежмент”, “Систем даяарх мэдээллийн системийн менежмент” гэх мэт өөр өөр нэрлэгээнүүд байгаа тул оновчтой нэрийг тодорхойлох	Шийдвэр гаргагч/Follow up: CNS/SG дэд ажлын хэсэг
Хэзээ: 2019 онд	Төлөв: Саналыг бэлтгэх
Хэн: <input checked="" type="checkbox"/> SWIM-ийн ажлын баг <input type="checkbox"/> CNS/SG дэд ажлын хэсэг <input type="checkbox"/> MANPING <input type="checkbox"/> ИНЕГ	

Шийдвэр 3.

Шийдвэрийн төсөл SWIM-1: SWIM Task Force 3-р хуралд IP бэлдэх	
Юу: APAC-ын SWIM Task Force 3-р хуралд МУ-аас тавигдах IP бэлдэх. Дараах сэдвээр IP бэлдэх. Үүнд: а. Систем даяарх мэдээллийн менежмент(SWIM)-ийн талаар МУ-ын өнөөгийн байдал, хэрэгжилт б. Систем даяарх мэдээллийн менежмент(SWIM)-ийг Монгол улсын агаарын навигацийн үйлчилгээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө.	Хүсэж буй үр дүнгийн нөлөөлөл: <input type="checkbox"/> Дэлхийн улс орнуудын хэмжээнд <input checked="" type="checkbox"/> APAC бүсийн хэмжээнд <input type="checkbox"/> Эдийн засаг <input type="checkbox"/> Байгаль орчин <input checked="" type="checkbox"/> Үйл ажиллагаа/Техникийн түвшинд
Яагаад: МУ-ын SWIM-ийн хэрэгжилтийн талаар, одоогийн байдлыг танилцуулах, судалгаа хийх, Ази номхон далайн бүсийн орнуудтай туршлага солилцох	Шийдвэр гаргагч/Follow up: SWIM-ийн ажлын баг
Хэзээ: 2019.04.20-ны дотор	Төлөв: Ажлын багаас IP-г бэлтгэх
Хэн: <input checked="" type="checkbox"/> SWIM-ийн ажлын баг <input type="checkbox"/> CNS/SG дэд ажлын хэсэг <input type="checkbox"/> MANPING <input type="checkbox"/> ИНЕГ	


Шийдвэр 4.

Шийдвэрийн төсөл SWIM-1: “Survey on implementation of SWIM services” судалгаа бөглөх	
Юу: Уг судалгааг SWIM-ийн ажлын баг болон SWIM-д хамааралтай бусад ажлын баг, ажлын хэсгүүдээр бөглүүлж, нэгтгэн ICAO-ын APAC-д хүргүүлэх	Хүсэж буй үр дүнгийн нөлөөлөл: <input type="checkbox"/> Дэлхийн улс орнуудын хэмжээнд <input checked="" type="checkbox"/> APAC бүсийн хэмжээнд <input type="checkbox"/> Эдийн засаг <input type="checkbox"/> Байгаль орчин <input type="checkbox"/> Үйл ажиллагаа/Техникийн түвшинд
Яагаад: SWIM-д хамааралтай ажлын баг, ажлын хэсгүүдэд SWIM-ийн талаар мэдээлэл өгөх, санал авах, одоогийн байдал ямар байгаа талаарх мэдээллийг ICAO-ын APAC-д илгээх зорилготой.	Шийдвэр гаргагч/Follow up: CNS/SG дэд ажлын хэсэг
Хэзээ: 2019.04.05	Төлөв: Шийдвэр гарсан.
Хэн: <input checked="" type="checkbox"/> SWIM-ийн ажлын баг <input type="checkbox"/> CNS/SG дэд ажлын хэсэг <input type="checkbox"/> MANPING <input type="checkbox"/> ИНЕГ	

Тайлан боловсруулсан:

Ажлын багийн ахлагч, НМҮА-ны дэд дарга

Ажлын багийн нарийн бичиг,
НМҮА-ний НТМХ-ийн өгөгдлийн инженер



Д.Үлэмж



У.Алтанцэцэг

2019.03.29